

Бөөрөгтийн хадны зураг: Монгол Алтайн эртний урлагийн өвөрмөц дурсгал

Ядмаагийн Цэрэндагва^{1,*}, Ричард Кортум², Баатарын Жаргалсайхан³

Товч агуулга: Энэ өгүүлэлд Баян-Өлгий аймгийн Буянт, Толбо сумын заагт орших Бөөрөгтийн голын сав дагууд тархсан хадны зургийн дурсгалын талаар өгүүлнэ. Бөөрөгтийн хадны зургийн дурсгал нь газар зүйн байршил, зураг сийлсэн хад чулууны олон янз байдал зэргээрээ ихээхэн өвөрмөц сонирхол татахуйц юм. Бөөрөгтийн голын хадны зургийн дурсгалуудын олон янз байдалд тулгуурлан тэдгээрийн онцлог, зарим өвөрмөц дүрслэлүүд, Монголын хадны зургийн дурсгалд эзлэх байр суурь, хадгалалалт хамгаалалтын асуудлыг хөндөн авч үзлээ. Бөөрөгтийн голын хадан зургийн дурсгалууд он цагийн хувьд чулуун зэвсгийн үеэс дундад эртний үе хүртлэх цаг хугацаанд хамаарна.

Түлхүүр үг: Хадны зураг, Бөөрөгтийн гол, янгир шүтлэг, бугын дүрслэл, хүрэл зэвсгийн үе, дүр, дүрслэл

Удиртгал

Баян-Өлгий аймгийн Буянт, Толбо сумдын зааг нутагт орших Бөөрөгтийн голын хөндийн хадны зургийн дурсгалын хадны зургийн дурсгалын аман мэдээг анх АНУ-ын Зүүн Теннесси их сургуулийн профессор Р.Кортум нутгийн ардаас сонсон тэмдэглэн авч, 2002 онд хүрэлцэн очиж газар дээр нь танилцаж байжээ. Улмаар 2004 онд тэрээр “Баян-Өлгий хадны зураг” экспедицийг зохион байгуулан уг газарт очиж урьдчилсан гүймэг судалгааг хийсэн байна (Kortum et al. 2005). 2005 онд Монгол-Америкийн хамтарсан “Баян-Өлгий хадны зураг-II” экспедици Бөөрөгтийн голд очиж нарийвчилсан хайгуул судалгааны ажил хийж, олон тооны хадны дурсгалт газрыг илрүүлэн олж, хуулга хийн, гэрэл зураг авч баримтжуулсан юм (Kortum, Tserendagva 2006; Цэрэндагва, Кортум 2006).

Бөөрөгтийн голын эх болон баруун эргийг эмжин тогтсон морены боржин, конгломерат, занарлаг чулуун тогтоцтой уулын хад чулуунаа олон тооны хадны зургийн дурсгалыг энэ нутагт нэн эрт үед амьдарч байсан хүмүүс цоолборлон сийлж үлдээсэн байна.

Бөөрөгтийн голын хөндийг дагасан 10 орчим км газарт, голын хөндийн энд тэнд тархсан том боржин хад болон, хоёр талын уулсын бэлийн ногоон, ногоовтор, хүрэн өнгийн занарлаг хад чулуунаа эртний хүмүүс өөрсдийн оюун ухаан, ертөнцийг үзэх үзэл, шүтлэг бишрэлийн илэрхийлэл болсон зураг урлалаа цоолборлон үлдээжээ. Дүрслэлийн арга болон хадны

зургийн дүр дүрслэл, зохиомжууд маш олон янзын дээр олон онцлог шинжүүдтэй. Бөөрөгтийн хадны зургийн дүр дүрслэлүүд Монголд Алтайн сүрлэг уулсын гайхамшигт дурсгалууд болох Цагаан Салаа, Бага Ойгор (Кубарев, Цэвээндорж, Якобсон 2005), Шивээт хайрхан, Түргэний хос толгой, Хөлцөөт, Арал толгойн хадны зургийн дурсгалууд дахь зарим дүр дүрслэлтэй адилсахын сацуу нутгийн өвөрмөц онцлогийг илтгэн ялгардаг.

Судалгааны арга зүй

Хадны зургийн дурсгалыг хээрийн нөхцөлд бүртгэн баримтжуулах арга зүйн дагуу явуулсан. Хадны зураг хайх хайгуулыг хийхдээ Бөөрөгтийн гол уруудан баруун эргийн боржин чулуун тогтоц бүхий уулын бэл, энгэр, оройн хэсгээр шугаман хайгуулын зарчмаар явуулсан бөгөөд хадны зураг илэрсэн газарт туг зоон тэмдэглэн уг дурсгалаа дараа нь очиж байршлыг нь тогтоох, хуулга хийн гэрэл зургаар баримтжуулан, тодорхойлолт хийх аргаар үргэлжлүүлэн судалж байв. Лабораторийн нөхцөлд гялгар цаасан дээр хуулсан хуулгаа фото аппаратаар гэрэл зургийг нь авч, компьютерт тусгай программд оруулан хэмжээг багасган хар зургийн горимд шилжүүлэн архивлах аргыг хэрэглэсэн.

Дурсгалт газрын байрлал, газар зүйн орчин

Бөөрөгтийн голын хадны зургийн дурсгалт газар Бөөрөгт Буянтын зоо нурууны зүүн этгээдэд Буянт сумаас зүүн урагш 40 км, Өлгий хотоос зүүн урагш (178°) 70 км-т оршино.

Бөөрөгтийн гол нь Баян-Өлгий аймгийн Буянт,


¹ ШВА-ийн Археологийн хүрээлэн, Чулуун зэвсгийн судалгааны салбар

² East Tennessee State University

³ ШВА-ийн Философийн хүрээлэн, Баян-Өлгий аймаг дахь салбар

* Холбоо барих зохиогч: tsedochoi@gmail.com

<https://orcid.org/0000-0002-8937-6447>



Зураг 1. А -Дурсгалт газрын байр зүй (Google Earth),
В -Хадны зургийн дурсгалт газруудын тархалт
(© Д.Содномжамц)

Толбо сумын зааг Буянт уулын зүүн сугаас эх аван урссаар замдаа Судагт, Нарийн зэрэг хэд хэдэн жижиг голтой нийлэн Цагаан Салаа голд цутган улмаар Мандах гол болон нэг салаа нь Толбо нууранд, нөгөө салаа нь Өмнө голд цутгадаг (Зураг 1).

Энэ голын хөндийд зуны цагт малчид олноор зусна. Харин намар, өвлийн цагт цөөн айл л намаржиж, өвөлждөг (Зураг 2). Өндөрлөг газар тул зуны сүүл сард сэрүү орж, эрт хүйтэрдэг. Цаг уурын хувьд эрс тэс уур амьсгалтай. Голын хөндийгээр морены дэнж, морены үхэр чулууд элбэг. Голын хөндийн баруун дээхэн цэнгэг уст Ногоон нуур бий.

Бөөрөгтийн голын эх Буянт уулын зүүн энгэр бэлийн хад чулуугаар зураг тун ховор, ганц нэгхэн янгир, бусад дүрслэлтэй. Харин Бөөрөгтийн гол

тохойрон хойд зүг чиглэн урсах газраас эхлэн зураг бүхий хад олширно. Хадны зургийг ихэвчлэн боржин чулуун тогтоц дунд тааралдах занарлаг ургаа хад, хүрэн элгэн хад, бор ногоон өнгийн хад чулуунаа сийлснээс гадна цөөн тохиолдолд том сондгой морены боржин бул чулууны тэгш толигор гадаргуу дээр сийлэн үлдээжээ. Зарим тохиолдолд том үхэр чулуун дээр хэдэн зуун зураг сийлсэн байх нь түгээмэл үзэгдэнэ.

Хадны зургийн дүр дүрслэл, дүрслэлийн арга барил


2005 оны судалгааны явцад Бөөрөгтийн голын хөндийгөөс 140 гаруй хаднаа дүрсэлсэн хэдэн зуун дүр дүрслэлийг олж бүртгэн баримтжуулсан юм. Хадны зургийн бүрдлийн хувьд авч үзвэл, хад чулуунаа ганц нэгхэн амьтдыг дүрсэлсэн байх нь нэн элбэг. Цөөн тохиолдолд нэг дор олон тооны амьтдыг зохиомжлон дүрсэлсэн нь бий. Тухайлбал зүүн эргийн уулын энгэрт буй нэгэн том боржин үхэр хадны дээд талын тэгш гадаргуу дээр нэг дор олон арван амьтдыг цоолборлон сийлсэн байх ба зохиомжийн хувьд өвөрмөц онцлогтой байна. Энд хоёр морь хөллөсөн байлдааны хөнгөн тэрэг, загварчилан урласан буга, мөчирөн эвэртэй буга, янгир, нум сум харваж буй морьтон зэрэг олон дүрслэлийг нэг дор багтаажээ (Зураг 10, 2). Ийнхүү үхэр чулуунд дүрсэлсэн олон тооны зураг өөр хэд хэд бий.

Бөөрөгтийн голын дагуух хад чулуунаа эртний урчууд тодорхой утга агуулга, тодорхой сэдэв зохиомж бүхий дүр дүрслэлийг бүх талбайгаар хонхойлон цохиж бодит байдлаар дүрслэх аргыг голчлон хэрэглэж өөрсдийн оюун санаа, ертөнцийг үзэх үзэл, хүрээлэн буй орчныг танин мэдэх сэтгэлгээний бодит илэрхийлэлээ хад чулуунаа мөнхлөн үлдээсэн ажээ. Дээр дурдсан аргаас гадна ан амьтан, дүр дүрслэлийг бүхэлд нь хөвөөлөн цохих, сараачин урлах аргыг цөөн тохиолдолд хэрэглэж байжээ.

Бөөрөгтийн голын хадны зургаас харахад янгирын зураг зонхилох бөгөөд ганц нэгээр нь дүрсэлсэн нь олон тохиолдоно. Түүнчлэн нэг дор олон тоогоор дүрсэлсэн янгирүүд ч тааралдаж байна. Янгираас



Зураг 2. Бөөрөгтийн голын хөндий (© Я.Цэрэндагва)



Зураг 3. Бөөрөгтийн голын
янгирын дүрслэл бүхий занар
бул хад (©Я.Цэрэндагва)

гадна Бөөрөгтийн хаднаа хүн, морьтон, тэрэг, адуу, үхэр, гахай, буга, чоно, нохой, ирвэс зэрэг олон амьтдыг сийлэн зурж үлдээсэн байна. Бид энэ удаад Бөөрөгтийн хаднаа дүрслэгдсэн янгир, бугын дүрслэлийн талаар дэлгэрэнгүй авч үзлээ.

Янгирын дүрслэл. Бөөрөгтийн хадны зургийн гол дүр нь янгир юм. Нийтдээ 460 гаруй янгирын дүрслэл бий. Тэдгээрийг ганц нэгээр нь сондгой хаданд цоолборлохоос гадна олноор нь нэг дор, бусад дүрслэлүүдийн хамт тодорхой зохиомжид оруулан гол болон туслах дүр болгон харуулах зэрэг олон янз байдлаар харуулсан байна.

Янгир дүрслэх арга ажиллагааны хувьд бүх биеийг хонхойлон цохих, нарийн зураасаар сийлэх, биеийн зарим хэсгийг хөвөөлөх гэсэн хадны зураг урлалын үндсэн аргуудыг ашиглажээ.

Бөөрөгтийн голын хөндийн дунд урсац дагууд байх нэгэн ногоон өнгийн занарлаг том бул ургаа хадны зүүн тийш харсан налуу хавтгайг өвч бүрхүүлэн олон тооны амьтад, хүн дүрсэлсэн байх нь бусад хадны зургийн дурсгалаас онцгойрон ялгарна. Энэ хаднаа 84 янгирын зураг байгаа нь Бөөрөгтийн голын хөндийд буй дурсгалуудаас хамгийн олон тооны янгир нэг дор цоолборлогдсон бүтээл болж байна (Зураг 3). Янгирыг нэг хаднаа бөөндүү дүрслэх явдал Монголын хадны зургийн дурсгалд түгээмэл хэдий ч Бөөрөгтийн голын сав дахь энэ хаданд сийлсэн шиг 80 гаруй янгирыг дүрсэлсэн зураг тун ховор юм. Энэ утгаараа энэ зургийн зохиомж, өгүүлэмж тун чухал ач холбогдолтой. Монгол Алтайн хадны зургийн дурсгал дотроос шүүн үзэхэд Цэнгэл сумын Далан Түргэний хос тогойн хаднаа нэг зурагт 20-30 орчим янгир (Цэрэндагва, Цэвээндорж 2016: 146, 214), Улаанхус

сумын Цагаан Салаа, Бага Ойгорын хаднаа 10-20 орчим янгир (Кубарев, Цэвээндорж, Якобсон 2005: 174, 394, 442, 477, 485), дүрсэлсэн зохиомжууд байна. Говь-Алтайн нурууны хадны зургийн дурсгал дотроос Говь-Алтай аймгийн Баян-уул сумын Ловонгийн нурууны хадны зурагт 10-40 орчим тооны янгир нэг хаданд дүрсэлсэн зохиомжууд байдаг (Монголын ... 2008: 179, 181, 189, 229, 326, 330; Баасандорж 2016: 43, 47, 84).

Гэхдээ эдгээр хаднаа янгирыг дүрслэхдээ тухайн зохиомжийн туслах дүр болгон томоор дүрсэлсэн амьтдын завсар зайд жижгээр, ав хоморгын гол тусгал болсон байдлаар дүрсэлсэн нь тод мэдэгдэнэ. Харин Бөөрөгтийн голын хувьд том хадны нэг талын бүх гадаргууг эзлүүлэн янгир дүрслээд, харин янгирын завсар зайд, үхэр, хүн болон бусад амьтдыг дүрсэлсэн байгаа нь содон өгүүлэмж болсон байх ажээ (Зураг 4, 1). Энэ бүхнээс үзэхэд Бөөрөгтийн голын хөндийн хүрэл зэвсгийн үеийн уугуул нүүдэлчид янгир шүтлэгийн хэвшмэл хэлбэртэй байсан болов уу гэсэн таамаг төрж байна. Хадны зургийн дүр дүрслэлд янгирын эзлэх хувь үнэмлэхүй давамгайлж байгаа байдал ч үүнийг батлана. Бөөрөгтийн голын хөндийд 10 гаруй км үргэлжилсэн хадны зургийн дурсгалт газруудад 460 гаруй янгир дүрслэгдсэн, тэдгээрийн олонх нь ямар нэгэн өөр төрлийн амьтадтай нэг дор бус дангаараа цоолборлогдсон байдал, ан авын тусгал болсон зохиомж цөөн байгаа явдал, ихэнхийг бодитоор, зарим тохиолдолд өвөрмөц хэв маягтай дүрсэлсэн зэргээс авч үзэхэд дээрх таамгийг батлан харуулах бодит баримт гэж үзүүштэй.

Бөөрөгтийн голын хөндийд орших, зураг бүхий 140 хадны 109-д дээр дурдсан 460 гаруй янгирын

дүрс сийлэгдсэн байгаа явдал энэ бүс нутгийн хүрэл зэвсгийн үеийн хадны зураг урлалын гол дүр, сэдэв нь янгир байсныг тодорхой илтгэн харуулна.

Янгирог ганцаар нь 32 хаданд (29,3%), хосоор 16 хаданд (14,7%) , 3-5 янгирог хамтад нь 23 хаданд (21,1%), олон тооны янгирог 12 хаданд (11 %), олон тооны амьтад бусад дүрслэлтэй хамтад олон янгирог 10 хаданд (9,2%), 3-5 янгирог ганц амьтантай хамт 2 хаданд (1,8%), өөр нэг амьтантай хамтад ганц янгирог 11 хаданд (10,1%), хос янгирог ганц амьтантай 1 хаданд (0,9%), хүнтэй хамт ганц янгирог 1 хаданд (0,9%) тус тус дүрслэн үзүүлсэн байна. Дээрх тоон үзүүлэлтээс харахад ганц янгир дүрслэх явдал давамгайлж байна. Мөн янгирог зөвхөн хосоор (Зураг 6, 3) болон 3-5-аар (Зураг 6, 4) нэг хаданд олон удаа дүрслэжээ. Бөөрөгтийн голын хадны зургийн нэг өвөрмөц онцлог бол янгир намнаж буй ан гөрөөг харуулсан зохиомж тун цөөн байгаад оршино. Янгирог ганц нэгээр, хос, цөөн сүргээр дүрслсэн байдлаас харахад дээр өгүүлсэнчлэн, хүрэл зэвсгийн үед янгир шүтлэгийн эртний хэлбэр энэ бүс нутагт дэлгэрсэн байсан нь тодорхой байна.

Янгирог загварчлан дүрслэх хандлага зарим зургуудад тод мэдэгдэнэ. Тухайлбал хэвлийг цагариг хэлбэртэй дүрслэн харуулсан зураг ихээхэн сонирхол татна (Зураг 5, 3). Уг янгирог Бөөрөгтийн голын баруун эргийн гол руу харсан нэгэн босоо том хаданд ганцаар дүрслсэн байх ба уг дүрслэлийн харалдаа доохно, голын хөндийд дугуй хүрээтэй хиргисүүр байгаа нь энэ хоёр дурсгалын уялдаа холбоог илтгэн харуулах мэт сэтгэгдэл төрөхөөр харагддаг. Өөр нэг янгирог эврийг задгай онгин хэлбэрээр гурав давхарлуулан гаргаж үзүүлсэн нь загварчлах сэтгэлгээний тод илэрхийлэл болж чадсан байна (Зураг 10, 5).

Он цагийн хувьд янгирог дүрслэлүүд хүрэл зэвсгийн үеэс дундад эртний үе хүртэлх цаг хугацаанд хамаарна.

Бугын дүрслэл. Бөөрөгтийн голын хөндийн хад чулуунд гуч гаруй бугын зураг байдаг.

Буга, согоог дүрслэхдээ эх биеийг хөвөөлөн сийлэх, бүх биеийг хонхойлон цохих аргыг тус тус ашиглажээ. Эх биеийг хөвөөлөн сийлсэн хоёр бугын зураг онцгойрон ялгарна. Биеийн ерөнхий хэлбэр төрхөөр нь согооны дүрслэл гэдэг нь мэдэгдэнэ. Энэ зураг Бөөрөгтийн голын эхийн зүүн талын уулын бэлийн хагарал ан цав ихтэй, хадны хагаар бүрхэгдсэн хадны дээд талын тэгш гадаргуу дээр байх ба хоёр согоог дээр доор зөрүүлэн биеийн тэгийг хөвөөлөн нарийн үзүүртэй багажаар тун өнгөцхөн сийлсэн байх ажээ. Дээд талын согоог сийлэхдээ биеийг зууван гонзгой хэлбэртэй гарган, сэрвээ хүзүүг үл мэдэг налуулан солбио нарийн урт чихтэй, толгойтой холбожээ. Хоншоорыг үл мэдэг шөвийлгөн гаргасан байх ба хүзүү, хэвлийг шулуунаар тэгшхэн гаргасан онцлогтой. Доод талын согооны хондлог өндөр

сэрвээг намхан гаргаад хүзүүгээ сунган толгойгоо сунган зогсоогоор дүрслэн үзүүлсэн аж (Зураг 10, 1). Хадны зургийн хадгалалтын байдлаас шалтгаалан энэ хоёр согооны зарим хэсэг тун бүдгэрсэн байх аж. Дүрслэлийн арга барил, хэв шинж зэргээрээ Бөөрөгтийн голын бусад дүрслэлээс эрс ялгарна. Чулуун зэвсгийн үед амьтныг хөвөөлөн цохих арга түгэн дэлгэрч байсан байсан бөгөөд Бөөрөгтийн голын хөндийд амьдарч байсан хүрэл зэвсгийн өмнөх үеийнхний урлагийн бүтээл ийнхүү мөнхрөн үлджээ гэж үзэж болохоор байна. Зургийн хажууханд мөн хоёр ч ийм дүрслэл байгаа хэдий ч маш ихээр элэгдэж өгөршсөн тул тодорхойлоход тун төвөгтэй болсон аж. Дээрх хоёр амьтан болон бусад цөөн тооны дүрслэлүүд тухайн газрын хамгийн өндөрлөг хэсэг буюу далайн түвшнээс дээш 2660-2670 м-ийн өндрөөс олдсон нь харьцангуй эрт үед холбогдуулан авч үзэх үндэслэлийн нэг болж байна.

Бусад бугануудыг хувьд төрөл бүрийн аргаар урласан байна. Биеийн ерөнхий хэлбэрийг тэгш өнцөгт хэлбэртэй гаргах (Зураг 7, 4), бодит байдлаар дүрслэх (Зураг 10, 4), өргөн, нарийн шулуун зураасаар цоолборлох (Зураг 7, 2; 8, 1) зэрэг дүрслэлийн олон янз байдал тодорхой харагдана. Буга дүрслэлийн гол илэрхийлэл болох эврийг урласан байдал ч олон янз. Хажуугаас харагдах байдлаар нь давхардуулсан дан болон бодит хос гэсэн хоёр үндсэн хэлбэртэй дүрслэн үзүүлсэн байна. Дан эвэртэй бугын хувьд ангилан авч үзвэл урагш салаалсан гэдгэр (Зураг 8, 1), хоёр тийш салаалсан гэдгэр (Зураг 8, 2), арагш салаалсан босоо (Зураг 8, 3), загварчлан долгиотуулсан эвэртэй (Зураг 5, 1) гэж хуваагдана.

Бугыг загварчлан урлах арга барил Бөөрөгтийн голын хөндийд хөгжсөн байсныг нэгэн зургаас тодорхой харж болохоор байна. Энд загварчилсан хоёр “монгол” буга, нэг согоог хадны төв хэсгийг эзлүүлэн, тэдгээрийн дээд талд нарийн зураасаар урласан буга, согоог цоолборложээ. Буга согоонуудыг тойруулан олон тооны янгир, морьтон, нум сумт морьт анчныг дүрслэн харуулсан байх аж. Голын хоёр бугыг харьцангуй ур сайтай дүрслэн харуулахдаа нэгний хошууг бодитоор нөгөөг шувуун хэлбэртэйгээр урлажээ (Зураг 5, 1). Өрнөдийн судлаачид хадны зураг дахь загварчилсан бугыг “монгол буга” хэмээн нэрлэж ирсэн (Fitzhugh 2009) бөгөөд бид ч энэ нэршлийг цаашид судалгаандаа ашиглах нь зүйтэй гэдэг саналаа энэ дашрамд дурдах нь зүйтэй.

Хос эврийг бодитоор үзүүлсэн бугын дүрслэлийн хувьд ац маягийн олон салаа эвэр зонхилж байна (Зураг 7, 2, 4). Цайвар өнгийн том боржин хадны бор өнгийн гялтага тогтсон дээд талын гадаргуу дээр найман янгир, чоно, нохой, үл танигдах амьтан, хоёр тэрэг зэргийг ихээхэн ур гарган дүрслэсний дотор арван нэгэн бугын зураг онцгойрон ялгардаг (Зураг

10, 2). Хадны бүх талбайг эзлүүлэн дүр дүрслэлүүдийг цоолборлохдоо тодорхой эрэмбэ дэс дараа баримталсан мэт сэтгэгдэл төрнө. Хадны зургийн дээд талд наран эвэртэй жижиг бугыг хадны орой руу хандуулан онцгойлон цоолборлосон байна (Зураг 10, 8). Түүний доод талаар том лагс зузаан, дөрвөлжин биетэй, мөчирөн эвэртэй, зургаан дайр бугыг хөвөөлөн цохисны хоёрын эвэр хэсгийн хад ховхорч сүйдсэн байна. Тэдгээрийн доод талд нэг урт мөчирөн эвэрт бугын толгойг уруу харуулан дүрсэлсэн байна. Нэг сонирхол татах дүрслэл бол уг бугын урд хөлний үзүүрээс дотогш салаалуулан цохиж, хэвтээ мөчирөн салангад эвэр урласан байгаа явдал юм. Бугын хөлөөс ийнхүү эвэр гарган дүрсэлсэн нь урлаачийн хийсвэр сэтгэхүйтэй холбоотой юу, эс бөгөөс хожим өөр цаг үед эвэр нэмж зурсан уу гэдгийг зургийн цоолборын өнгөний ялгамжаар тандан мэдэх бололцоогүй. Ямартай ч нэг цаг үед зурсан мэт харагдах ба Бөөрөгтийн голын хөндийд буга дүрслэлийн нэгэн өвөрмөц арга илэрч олдсон нь энэ юм. Энэ бугын хоёр хөлний харалдаа сэлмэн эвэрт янгир, чоно байх ба хоёуланг хадны өөд хандуулан дүрсэлжээ. Харин түүний цээжний харалдаа урд, загварчилсан бугыг жижгээр урласан нь анхаарал татна. Уг бугын доод талд хоёр мөчирөн эвэртэй том бугыг дүрсэлсний нэгний хүзүүг нэлээд уртаар гаргажээ. Дээрх мөчирөн эвэртэй адилхан боловч хэмжээгээр арай жижиг зургаан буга хоёр согоог өөр нэгэн боржин хаданд сийлсэн нь (Зураг 7, 4) буга урлалын энэхүү хэв маяг Бөөрөгтийн голын хөндийд хүрэл зэвсгийн үед түгэн дэлгэрснийг илтгэн харуулна.

Бөөрөгтийн голын голын хөндийгөөс бүртгэн баримтжуулсан хадны зургийн дээр онцлон авч үзсэн янгир, бугаас гадна морьтон, чоно араатан, аргаль, адуу, үхэр, үл танигдах амьтан, хүн, нохой, тамга тэмдэг, өвөрмөц дүрслэл, ирвэс, тэрэг, нарны дүрслэл, тэмээ, гахай зэрэг олон тооны дүр дүрслэлүүд бий.

Морьтонгуудын дүрслэл хорь гаруй байх ба голчлон олон тооны амьтдын хамт дүрслэгджээ. Нэг зурагт “монгол буга” олон тооны ан амьтдын дунд гурван морьтонг дүрсэлсэн байх ба нэг морьтон нь нум хөвчлөн татаж байгаагаар дүрслэгдснээс харахад Бөөрөгтийн хаднаа ховор дүрслэгдсэн ан гөрөөний сэдэвт зураг болох нь илэрхий байна. (Зураг 5. 1).

Дундад эртний улсуудын үед холбогдох нэгэн зурагт олон тооны янгирүүдыг хүрээлсэн зургаан морьтон дүрслэхдээ морь унаачийн хөлийг унжуулалгүй үзүүлсэн нь он цагийг тодруулах чухал хэрэглэгдэхүүн юм. Харин хүрэл зэвсгийн үеийн хадны зурагт хүнийг морио зайдан унасан байдлаар хөлийг унжуулан дүрсэлсэн нь түгээмэл байна (Зураг 10, 6).

Чоно араатанг голдуухан янгир, аргаль, бугыг хөөж ноцож, хоргоож байгаагаар дүрслэн үзүүлжээ

(Зураг 5. 2; 6.6; 7. 1-2; 9. 1).

Үхрийн дүрслэл хэдийгээр цөөвтөр хэдий ч хүрэл зэвсгийн үеийн дүрслэлийн арга барицыг тод томруун илтгэн харуулна (Зураг 4. 2; 6. 1; 9. 4, 5, 8). Тухайлбал, хоёр тийшээ сэлжийсэн үзүүр бүхий даргар том эвэртэй, нарийн хоншоортой, сэрвээ, хондлой том, дугуйрсан үзүүртэй урт сүүлтэй нэг үхрийн дүрслэл тод ялгарч байна (Зураг 9, 8).

Адууны зураг цөөвтөр ч заримын биеийн хэлбэрийг өөр амьтныхтай тун төстэй байдлаар харуулсан зураг ч тааралдана. Тухайлбал нэг зурагт буган цээж, сэрвээтэй, шодон сүүлтэй адууг дүрсэлжээ (Зураг 7, 4). Мөн ийм төрхийн хоёр ч адууг нэг үхэр, өвөрмөц дүрслэлийн хамт урласан байна (Зураг 6, 1).

Гахайн дүрслэл ганц бүртгэгдсэн нь том зантгар толгойтой дөрвөлжин хоншоортой, лагс зузаан биетэй харагдана (Зураг, 9, 3).

Явган хүний дүрслэл цөөвтөр байгаагийн хоёрыг олон тооны амьтдын дунд гараа алдлан зогсоогоор, нэгийг даргай эвэртэй үхрийг харваж байгаагаар дүрслэн үзүүлжээ (Зураг 4, 2). Хүнийг толгойн өмсгөлтэй дүрслэн харуулсан зураг ч байна. Дөрвөлжин занарлаг хавтгай хаднаа чихтэй малгай өмссөн хүнийг ямар нэг амьтныг тэгнэн өргөж зогсоогоор урласан зураг тун сонирхолтой (Зураг 9, 2).

Бөөрөгтийн голын хоёр тэрэгний зураг бусдаас ихээхэн тодорч ялгардаг. Уг хоёр тэрэгний дугуйг харьцангуй жижгээр харуулсны дээр хэгээсгүй битүү болох нь тодорхой мэдэгдэнэ. Ганц урт гуя, дугуйвтар тавцантай, хөндлөн буулгатай энэ тэргэнд тус бүр хоёр морь хөллөсөн мэт харагдах авч тэдгээр нь тодорхой сайн ялгарч мэдэгдэхгүй байх ажээ (Зураг 10, 3).

Бөөрөгтийн голын хадны зургийн хадгалалт хамгаалалт

Бөөрөгтийн голын хадны зургууд д.т.д. 2610-2670 м-ийн өндөрт байрлах, голын хөндий дагасан эртний морены боржин чулуу, занарлаг хад чулуунаа сийлэгдсэн байх бөгөөд байгаль цаг уурын эрс тэс уур амьсгал, өвөл зуны агаарын хэмийн хэт их өөрчлөлтөөс шалтгаалан эвдэрч, элэгдэж өгөрших үйл явц эрчимтэй явагдсан нь тод мэдэгдэнэ. Хадны зураг бүхий хад хагарч ан цав гарах, боржин чулууны зураг бүхий гадаргуу хуурч ховхорсон байдал түгээмэл байх ажээ. Харин хүний бусармаг үйл ажиллагаатай холбоотойгоор хадны зургийн дээр сараачих, нэр усаа бичиж сүйтгэсэн байдал тун цөөн байгаа нь сайшаалтай юм.

Цаашид Бөөрөгтийн голын хөндийд байх хадны зургийг аймаг орон нутгийн хамгаалатад авч, хадгалалт хамгаалтад нь анхаарал тавих, гайхамшигт зурагт бүхий хэд хэдэн том бул чулуудыг хашаалж

хамгаалах, самбаржуулах, улмаар аялал жуулчлалын бүтээгдэхүүн болгох нь зүйтэй гэсэн санааг дэвшүүлж байна.

Товч дүгнэлт

Бөөрөгтийн голын хадны зураг нь Монгол Алтайгаас илэрч олдсон хадны зургийн томоохон дурсгалт газар гэдэг нь тодорхой юм. Энэхүү хадны зургийн цогц дурсгалын гол сэдэв нь ан амьтад байна. Эртний урчууд хад чулуунаа ан амьтад, бусад дүрслэлийг бүх талбайгаар хонхойлон цохих аргаар голчлон зурж сийлж байжээ. Дээрх аргаас гадна амьтны биеийг бүхэлд нь хөвөөлөн цохих, сараачин урлах аргыг цөөн тохиолдолд хэрэглэж байсан нь тодорхой байна. Ан амьтаас янгирын зураг дийлэнх хувийг эзлэх бөгөөд нийтдээ 460 гаруй янгирын дүрслэл цоолборлогджээ. Янгирыг өөр төрлийн амьтдын хамт бус ганц нэгээр, хос, цөөн сүргээр, зарим тохиолдолд цөөн тооны амьтад, хүний дүрслэлтэй хамт их олноор дүрсэлсэн байдлаас харахад хүрэл зэвсгийн үед янгир шүтлэгийн эртний хэлбэр энэ бүс нутагт дэлгэрсэн байжээ гэсэн дүгнэлтэд хүрч байна.

Янгиргаас гадна Бөөрөгтийн голын хаднаа хүн, морьтон, тэрэг, адуу, үхэр, гахай, буга, чоно, нохой, ирвэс зэрэг сэдэв агуулга зохиомжийн хувьд хосгүй дүрслэлүүд олон байгаа нь энэхүү дурсгалт газрын танин мэдэхүйн ач холбогдлыг илтгэн харуулна.

Бөөрөгтийн голын хадны зургуудаас хамгийн эрт үед холбогдох нь бидний үзэж байгаагаар чулуун зэвсгийн үед холбогдоно. Хүрэл зэвсгийн үеийн хадны зургууд дийлэнх хувийг эзлэх ажээ. Мөн түүнчлэн төмөр зэвсгийн эхэн үе, дундад эртний нүүдэлчдийн үлдээсэн урлагийн дурсгалууд нэлээдгүй байна.

Хадны зургийн дурсгалд үзүүлэх хүний үйл ажиллагаатай холбоотой эрсдэл хэдийгээр бага байгаа боловч зуны цагт айлууд ихээр нутаглах тул малын хөлөөс шалтгаалсан тодорхой хэмжээний эрсдэл үүсэн бүрэлдэх нөхцөл нэгэнт бий болсныг аймаг орон нутаг, Дэлхийн Өв-Монгол Алтайн нурууны хадны зургийн цогцолбор дурсгалт газрын хамгаалалтын захиргаанаас анхааралдаа авч хадгалж хамгаалах, судлан шинжлэх цогц төлөвлөгөө гарган ажиллана гэдэгт найдаж байна. Мөн зураг бүхий хад чулууны дотоод элэгдэл өгөршил хамгийн их эрсдэл учруулах хүчин зүйлийн нэг гэдгийг цохон дурдъя. Бидний судалгаа Бөөрөгтийн голын эх, дунд биеийг голлон хамарсан бөгөөд цаашид уг голын адаг, салаа цутгалын хөндий, Ногоон нуурын эхээд хайгуул судалгаа хийхэд хадны зургийн гайхамшигт дурсгалууд шинээр илэрч олдох нь дамжиггүй юм.

Талархал. Хээрийн судалгааны ажилд оролцон Монгол Алтайн хатуу ширүүн байгалийн үнөхцөл байдлыг үл хайхран хамтран судалгаанд оролцсон С.Булган, Б.Манлайбаатар, Н.Гарднер, С.Болатбек,

С.Бота нартаа чин сэтгэлийн талархал илэрхийлж байна.

Abstract

Petroglyphs of Buurugt: A unique site of ancient art in the Mongolian Altay

Yadmaa Tserendagva, Richard Kortum,
Baatar Jargalsaikhan

This article examines the rock paintings scattered across the basin of the Buurugt River, located on the border between the Buyant and Tolbo Sums in Bayan-Olgii Province. The Buurugt rock painting monument is a distinctive site due to its unique geographical location and the diversity of its rock art. Drawing on the variety of rock art monuments along the Buurugt River, this article explores their features, distinctive characteristics, their role within Mongolian rock art, and the challenges associated with their preservation and protection. Historically, the rock art monuments of the Buurugt River span from the Stone Age to the Middle Ages.

Keywords: Rock art, Buurugt River, ibex worship, Mongolian deer illustrations, Bronze Age, symbolism, imagery.

Ном зүй

Баасандорж, Г. (2016). Ловонгийн нурууны хадны зураг. УБ.

Кубарев, В.Д., Цэвээндорж, Д., Якобсон, Э. (2005). Петроглифы Цагаан-Салаа и Бага-Ойгура. Новосибирск.

Монголын ... (2008). Монголын Говь-Алтайн хадны зураг. Сөүл (монгол, солонгос хэлээр).

Цэрэндагва, Я., Цэвээндорж, Д. (2016). Далан Түргэний хос толгойн хадны зураг. УБ.

Цэрэндагва, Я., Кортум, Р. (2006). Монгол-Америкийн хамтарсан археологийн экспедицийн Баян-Өлгий аймгийн Толбо, Цэнгэл сумдын нутагт хийсэн хадны зургийн судалгааны ажлын тайлан. УБ.


Fitzhugh, W. (2009). Stone Shamans and Flying Deer of Northern Mongolia: Deer Goddess of Siberia or Chimera of the Steppe? *Arctic Anthropology*, 46 (1-2): 72-88. DOI: <https://doi.org/10.1353/arc.0.0025>

Kortum, R., Batsaikhan, Z., Edelkhan & Gambrell, J. (2005). Another New Petroglyph Complex in the Altai Mountains, Bayan Olgii Aimag, Mongolia: Biluut 1, 2 and 3. *INORA*, 41: 7-14.




Kortum, R., Tserendagva, Ya. (2007). Boregtiin Gol: A New Petroglyph Site in Bayan Olgii Aimag, Western Mongolia. *INORA*, 47: 8-15.

Received: Oct. 02, 2024; Revised: Nov. 25, 2024; Accepted: Dec. 16, 2024







Зураг 4. Бөөрөгтийн голын хөндийн хадны зураг




Зураг 5. Бөөрөгтийн голын хөндийн хадны зураг




Зураг 6. Бөөрөгтийн голын хөндийн хадны зураг




Зураг 7. Бөөрөгтийн голын хөндийн хадны зураг



Зураг 8. Бөөрөгтийн голын хөндийн хадны зураг



Зураг 9. Бөөрөгтийн голын хөндийн хадны зураг



Зураг 10. Бөөрөгтийн голын хөндийн хадны зураг (© Р.Кортум, Я.Цэрэндагва)